



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 28 өдөр


Дугаар 4/106

Хужирт сум

Бэлчээр чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 1 дүгээр багийн нутаг Мухар, 2 дугаар багийн нутаг Бургас, Тээл, 3 дугаар багийн нутаг Уньт, Сайрт, 6 дугаар багийн нутаг Асгатын энгэр, Урд хадаргантай, Хойд хадаргантай, Хуурай, Шарт, Засмал орчмын бэлчээрийг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд малын хөлөөс чөлөөлсүгэй.
2. Нутаг чөлөөлөх 2 дугаар багийн урд хэсэг болон 1, 6 дугаар багийн малчид Ногоон бүрд, Сахилдагтай, Сүвээ, Модот, Хар тойром, Арлын ухаад нутаглахыг даалгасугай.
3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, малчин өрхүүдэд мэдээлэл хүргэж ажиллахыг холбогдох багийн Засаг дарга нар, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бямбасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Мөнхбат)-д даалгасугай.



ОРЛОГЧ

Б.ДЭМБЭРЭЛ